

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2021 оны 06 дугаар сарын мэдээ

2021.06.24

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлыг цахимаар хуралдуулж Ардын хувьсгалын 100 жил, Боловсролын байгууллагын 100 жилийг тохиолдуулан төр захиргааны болон боловсролын байгууллагад ажлын өндөр амжилт гаргасан 11 иргэнийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Аймгийн ИТХ-д уламжилсан.

Эх үрсийн баяраар “Алдарт эх”-ийн 2 дугаар зэргийн одонгоор шагнагдсан 18 эхэд одонг гардуулсан.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

. Тухайн сард дээд газраас 21 албан бичиг ирсний 7 нь хариутай 2 –нь хугацаандаа, 5–нь хугацаа болоогүй байна.

2021 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн А/68 тоот захирамжаар сумын төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн шалгарсан төслүүдэд сум хөгжүүлэх сангийн журмын дагуу гэрээ байгуулан зээлийг олгосон.

2021 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн А/72 тоот захирамжаар 2021 оны хагас жилийн малын түүвэр судалгааг явууллаа.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ.

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг 38,9 сая төгрөг авахаас 5,8 сая төгрөг орж ирсэн. Тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу бүрэн олгогдсон.

Аймгаас авах санхүүгийн дэмжлэг, төсвийн орлого төсөв төлөвлөгөөний дагуу санхүүжигдсэн.

Байгууллагын өр авлага, төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн.

Статистикийн байгууллагад хүргүүлэх жилийн эцсийн болон сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж, 2021 оны хагас жилийн үүвэр судалгаанд 6 багийн нийт 197 өрх хамрагдан судалгааг авч цахим санд шивсэн.

Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтын дансаар ундны усны хөнгөлөлт, хагас жилийн мал тооллогын зардлыг хуваарийн дагуу олгоод байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Олон нийтийн арга хэмжээг хориглосонтой холбоотойгоор сургалт мэдээлэл, хурал зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулж байна. Эрх зүйн ажлын хагас жилийн тайлан мэдээг хууль зүйн хэтэтс хүргүүлсэн.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Ерөнхий боловсролын сургууль: МУБШУ-ны сайдын 2021 оны 05 сарын 06 –ны А/165 тушаалын дагуу багш нарын амралтыг 06 сарын 01-ны өдрөөс эхлүүлсэн. Байгууллага хамт олноороо хичээлийн жилийн ажлын үнэлгээ дүгнэлтээ нэгтгэн багш

ажилчидтайгаа ганцаарчлан уулзаж тайланг хамгаалуулан ирэх хичээлийн жилд хийх бүтээлч ажлын саналуудаа хэлэлцэн ажлын чиглэл өглөө.

Анги дэвших төгсөх, БМСС дүн мэдээ шивэх, цахим журнал хөтлөх, гэрчилгээ бичиг баримт бичих хэвлэх, баталгаажуулах, олгох, байгууллагын эд хөрөнгө өмчийн тооллогын комисс томилох зэрэг тушаал шийдвэрийг холбогдох хууль, дүрэм журмыг баримтлан боловсруулж гаргасан.

ЭЕШ сорил болон багш нарын даалгаврын сангийн боловсруулалтанд бүрэн хамрагдаж амжилттай дүгнэлт авсан.

12 ангиа амжилттай төгсөж буй төгсөгчдөд сумын засаг дарга, сургуулийн захиргаанаас хүндэтгэл үзүүлэн шагнаж урамшуулан гэрчилгээг гардуулав. Шагнал урамшилд зарцуулсан төсөв-237.000 төг.

-5,9 анги төгсөгчдөө ирэх хичээлийн жилийн эхэнд “Би дэвшлээ” хөтөлбөрийн хүрээнд хичээлийн жилийн нээлтэн дээр гэрчилгээ батламжийг гардуулахаар төлөвлөсөн болно.

Сургалтын менежерүүд болон 12 дугаар ангийн анги удирдсан багш нар элсэлтийн ерөнхий шалгалт өгөх сурагчдын тоог гарган Баруун-Уртад ковид цар тахлын халдвар ихэссэнтэй холбогдуулан сурагчид халдвар хамгааллын дэглэмээ сайн баримтлах, бөөгнөрөхгүй байх, ирж суух хамаатах саднаа урьдчилан судлах зэрэг чиглэлийг эцэг эх асран хамгаалагчдад хүргэж, судалгаануудыг хурдан шуурхай авч цаг үетэй холбогдсон мэдээ мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаж байна.

Сумын ОНХС-ийн 15,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар спорт заалны шалыг шинэчлэх ажил хийгдэж байна.

Мөн “Ковид-19” цар тахалын халдвар ихэссэнтэй холбогдуулан ээлжийн амралтаа аваагүй ажилчид сургуулийн захиргаанаас гаргаж өгсөн хуваарийн дагуу постонд гарч, орох гарах хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.

Эрүүл мэндийн төв: Тухайн сард нийт үзлэгт 2400 хүн хамрагдсан. Больницод хэвтэн эмчлүүлсэн нийт 28 хүнээс хүүхэд – 1, Алсын дуудлага - 28 ирснээс 0-5 насны хүүхдийн дуудлага 1 байна. Ирсэн дуудлага бүрийг хугацаа алдалгүй шийдвэрлэсэн.

Ковид-19 халдварын түргэвчилсэн шинжилгээг 384 иргэнд хийж 5 иргэний шинжилгээ эерэг гарсныг PCR шинжилгээгээр баталгаажуулж АНЭ-т шилжүүлсэн. Голомтын эцсийн ариутгал 558 мкв урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл 3205мкв талбайд хийсэн. Голомтод бүс нутгаар зорчин ирсэн иргэдийг гэрийн ажиглалтын хугацаа дууссан өдөр ковид-19 халдварын түргэвчилсэн шинжилгээг авч ажиллаж байна.

Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх Хятад улсын Синофарм үйлдвэрийн Вероцелл вакцины 2 дахь тунг 18-с дээш насны 3257 иргэнээс 2904 иргэнийг вакцины 2 тунд хамруулж 89,2%-тай байна.

АНУ-ын Пайзер вакцины дархлаажуулалт 16-17 насны 144 хүүхэд, жирэмсэн эх – 31, архаг хууч өвчтэй 47 иргэнг хамруулж дархлаажуулалтын 1-р тун 100%-тай байна.

Цэцэрлэг: 6 дугаар сарын 2-ны өдрөөс бүлгийн багш нар, туслах багш нарын ээлжийн амралт эхэлсэн.

Соёлын төв: Олон улсын хүүхдийн баярыг тохиолдуулан “Хүүхдийн ертөнц” цахим уралдааныг “Ээжтэйгээ дуулъя” 1-5-р анги, “Ковидгүй зун миний нүдээр” гар зургийн уралдаан 5-9-р анги гэсэн 2 насны ангилалаар зохион байгуулж дүгнэлээ.

“Алдарт эх” одон гардуулах ёслол хүндэтгэлийн ажиллагаанд зориулж “Ижий танаа” хүндэтгэлийн тоглолт бэлтгэн тоглолоо.

Байгууллагын цахим хаягт соёл урлагийн болон цаг үеийн нөхцөл байдлын мэдээ мэдээлэл, КОВИД-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж зэрэг мэдээ мэдээллүүдийг тогтмол оруулан ажиллаж байна.

Хорио цээрийн дэглэмийн үед номын сангийн үйлчилгээг ард иргэдэд цахимаар хүргэхэд анхаарч 1 роман 8 өгүүллэгийг цувралаар оруулж уншигчиддаа хүргэлээ. 12 уншигчдад 43 номыг гэрээр олгож үйлчиллээ.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: Ерөнхийлөгчийн 63 тоот зарлигийн дагуу бүх нийтийн мод тарих өдрөөр суулгаж, тарисан 500 суулгацын усалгаа, арчилгааг хийж ажиллаж байна.

Иргэдийг хогийн нэгдсэн цэгт хог хаягдал төвлөрүүлэх ажилд байнгын хяналт тавин ажиллаж байна.

Дэлхийн байгаль орчны өдрийг тохиолдуулан “Зогсооё, Залруулъя, Засъя, уриан дор “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, хог хаягдлын тухай хууль, амьтны тухай хууль, усны тухай хууль зэрэг хуулиудыг сурталчилах 7 хоногийн аяныг зарлаж 7 ААНэгжийг байгаль орчинд нөлөөх байдлын үнэлгээнд оруулах бичиг баримтыг холбогдох газарт хүргүүлсэн. Мөн Блок үйлдвэрлэж байгаа 5 иргэнтэй түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөрийг хийх гэрээ байгуулан ажиллаа.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Ургамлын гарал үүсэл, пестицидийн бүртгэл хяналтын систем цахим сургалтад хамрагдаж, өрхийн тариалан эрхлэгчдийг цахим бүртгэлд бүртгэсэн. Хаврын тариалалтын мэдээг аймгийн ХХААГ, статистикийн хэлтэст программд шивж мэдээллийг хүргүүлсэн.

Төмс 16 иргэн, 1 аж ахуй нэгж 1,4 га талбайд, хүнсний ногоо 1,111 га талбайд 10 нэр төрлийн хүнсний ногоо тариалсан.

Сумын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг 7 хоног бүрийн 1,4 дэх өдрүүдэд аймгийн ХХААГазарт хүргүүлж байна.

Улсын Онцгой Комиссын даргын “Түр журмыг шинэчлэн батлах тухай “ 41 дүгээр тушаалын дагуу “Хоол үйлдвэрлэл, хүнс худалдаа үйлчилгээний газруудын хоол, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр худалдаа үйлчилгээний газруудад зөвлөмж хүргүүлж, хяналт тавьж өдөр бүр аймгийн МХГ-ын хүнсний байцаагчид мэдээллийг өгч ажиллаж байна.

Гамшгийн үеийн болон стартегийн хүнсний нөөц бүрдүүлэхээр 2 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулж Засаг даргаар батлуулсан.

06 дугаар сард СХС-ийн зээлийн эргэн төлөлт 5,2 сая төгрөг, хугацаа хэтэрсэн 1 зээлдэгч зээлийн өрийг бүрэн барагдуулсан. 1 иргэнд гахай, тахианы аж ахуй эрхлэх чиглэлээр 10,0 сая төгрөгийн зээлийг олгосон.

Мал төллөлт, бойжилт, том малын хорогдлын мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр ХХААГазарт, сар бүрийн эцэст статистикийн хэлтэст программд шивж орууллаа. Малын хорогдол бүгд -8698, адуу- 91, үхэр- 456, хонь- 3970, ямаа- 418, мал төллөлт бүгд -157614, ингэ- 112, гүү- 4566, үнээ- 6625, эм хонь- 94119, эм ямаа- 52192 буюу нийт хээлтэгчийн 72,1 % төллөсөн байна. Сумын малчин өрхийн дэмжлэгт хамрагдсан 795 малчдын жагсаалтыг гаргаж аймгийн ХХААГазраар дамжуулан Сангийн яаманд хүргүүлсэн.

Мал эмнэлэгийн чиглэлээр : Сумын засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 18-ны А/64 тоот “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын вакцинжуулалт хийх тухай” МЭГ-аас 225400 тун вакцин татан авч сумын гоц халдварт шүлхий өвчнөөр өвчлөмтгий үхэр-28975 бог-166317 нийт 195292 толгой мал тарьж 224267 вакцин зарцуулж 2021 оны 06 сары 02-нд тарилга дууссан.

“Мал сүргийг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” Сумын засаг даргын А/56 захирамжийн дагуу малын эмч нар болон малчдад заавар зөвөлгөө өгсний дагуу энэ ажилд татан оролцуулж дотор, гадна шимэгчийг устгах зорилгоор мал сүргийг боловсруулалтанд үхэр- 4820, бог-26030, туулгалтанд бод- 3546, бог-73100, нохой-232, угаалганд бод-6925 бог-30870 тус тус хамрагдаад байна.

Мал эмнэлэгийн ерөнхий газраас зүүн болон төвийн бүсийн бог малын мялзан, шүлхий өвчний байгалийн халдварын тандалт хийх талаар цахим хурал сургалт мэдээлэлд хамрагдаж тандалтын системд хэрхэн ажиллах талаар хувийн мал эмнэлэгүүдэд / Агарданшүг ХХК /заавар зөвлөмж өгч ажилласан.

Тус сумаас сонгогдсон нэр бүхий 7 малчин өрхийн үхэр-28, хонь-42, ямаа-42 нийт-112 толгой малд тандалт хийхээр Агарданшүг ХХК-ийн эрхлэгч Г.Эрдэнэчимэгтэй хамтран ажиллах цэгүүдийн маршрут зураглалыг гарган аймгийн мал эмнэлэгийн газарт хүргүүллээ. Нийт 7 цэгийн 198 км.

Аймгийн мал эмнэлэгийн газраас орон нутгийн бог малын дотрын халдварт хордлого өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин-119,2 л, сахуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 48 л-ийг татан авч мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд хуваарилан өгсөн.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн